

СУРГУУЛИЙН ОРЧИНД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

БАГЦ МАТЕРИАЛ

**"ЗУДАД НЭРВЭГДСЭН МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДЭД
БОЛОВСРОЛЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, СУРГУУЛЬД ТҮШИГЛЭН
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ" төсөл**

Хэрэгжих хугацаа:

2016.08.01-2017.01.31

Төслийн зорилго:

Зудын улмаас малчдын хүүхдүүдэд учирсан сөрөг нөлөөг боловсролоор дамжуулан бууруулах, зорилтот сургуулиудын гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа:

- Малчдын хүүхдүүдэд боловсролын дэмжлэг үзүүлэх
- Сургуулийн орчинд гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжих

Төсөл хэрэгжих аймгууд:

Архангай, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн 19 сум, 5 баг

СУРГУУЛИЙН ОРЧИНД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

БАГЦ МАТЕРИАЛ

Багцын агуулга

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг сургуулийн орчинд зохион байгуулахад шаардагдах зарим мэдээллээс бүрдсэн энэхүү багцад дараах мэдээлэл багтсан болно:

1	Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж	3
2	Сургуулийн орчинд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх жишээ	9
3	Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоог хангах зөвлөмж..	13
4	Гамшгийн үед хүүхдэд ээлтэй орон зай бүрдүүлэх зөвлөмж	15
5	Гамшгийн үед боловсролын үйлчилгээ үзүүлэх зөвлөмж	17
6	Гамшгийн үед жендэрээс үүдэлтэй хүчирхийллээс сэргийлэх зөвлөмж..	19
7	Гамшгийн үед төөрсөн хүүхдэд туслах зөвлөмж	23
8	Сэтгэлийн зовуурьтай хүүхдэд туслах зөвлөмж	25
9	Гамшгийн эрсдэлийг бууруулах сургуулийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд туслах 9 чухал эх сурвалж	29

Багцын зориулалт

Энэхүү багцыг сургуулийн орчинд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллах багш нар болон удирдах ажилтнуудад зориулан боловсруулав. Багш, удирдах ажилтан энэхүү зөвлөмж болон бусад холбогдох материалуудад тулгуурлан, сурагчид, тэдний эцэг эхийн зөвлөл, ажилчид, бусад байгууллагуудтай хамтран “Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх, сайжруулан хэрэгжүүлэх ажлыг тасралтгүй гүйцэтгэнэ.

ГАМШГИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Эрсдэл, эмзэг байдал	Аюулд өртсөн тохиолдолд нэн даруй хийх зүйл	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
1. Газар хөдлөлт		
<ul style="list-style-type: none"> • Даацын хана, баганад тэмдэглэгээ тавиагүй байх • Аврах гарц цоожтой, чөлөөтэй биш байх • Хүнд, том тавилгыг хананд бэхлээгүй байх • Хагарах шилэн эдлэл, хүн гэмтээх зүйлийг гарцын хаалганы ойролцоо байрлуулах • Аюулгүй талбай, цугларах газраа хүмүүс мэдэхгүй байх • Хүүхдүүд “хэвт, нуугд, хүлээ” зарчмыг мэдэхгүй байх • Гүйхгүй, түлхэхгүй, хоорондоо ярихгүй, буцаж гүйхгүй зарчмыг мэдэхгүй байх • Газар хөдлөлтийн үед хэрэглэх нөөцийг бүрдүүлээгүй байх • Өөрийгөө болон бусдад туслах аргаа мэдэхгүй байх • Галын аюулаас урьдчилан сэргийлэх, хохирол багатай давах аргуудыг мэдэхгүй байх 	<ul style="list-style-type: none"> • Тайван байж чичирхийллийг зогстол толгойгоо хамгаалан аюулгүй газар хорогдох (даацын хана, булан, багана дор, хаалга онгойлгон доор нь зогсох) • Дээрээс унах эд зүйл, цонхноос хол байх • Цахилгаан шат хэрэглэхгүй байх • Цахилгаан хэрэгслийг салгах • Өндөр барилгаас холдож, аюулгүй ил газар очих • Өөрийгөө бэртсэн гэмтсэн эсэхийг шалгах • Тусламж дуудах • Гэмтэж бэртээгүй бол бусдад туслах, ялангуяа бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өндөр настанд туслах 	<ul style="list-style-type: none"> • Амьдардаг газар, өрөө тасалгааны хаана нь аюулгүй газар байгааг мэдэж авах, тэмдэглэх • Аюулгүй газарт очих дадлага сургуулилт хийх • Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадварт суралцах • Хүнд, том тавилгыг хана, таазанд сайтар бэхлэх • Наад зах нь гурван хоногийн хүнс, усны нөөцтэй байх • Гар чийдэн, радио, батерей, дулаан хувцас, бичиг баримт, бэлэн мөнгө зэргийг бэлэн байлгах • Гэр бүлийн гишүүд бие биенээсээ салсан тохиолдолд хаана уулзахаа тохирох • Ус, цахилгаан, хийн хоолойг хааж, салгаж сурах • Шаардлагатай утасны жагсаалтыг хүүхдэд чээжлүүлэх, тусламж дуудаж сургах • Газар хөдлөлтийн гамшгийн талаар мэдээлэл өгч, дадлага сургуулилт тогтмол хийх
<p>Газар хөдлөлтийн гамшигт хүүхэд өртсөн тохиолдолд дараах эрсдэл учирч болзошгүй: Гэмтэх, бэртэх, угаартах, түлэгдэх, амьсгал боогдох, хөгжлийн бэрхшээлтэй болох, хүчирхийлэлд өртөх, сэтгэл санааны хямралд орох, төөрөх, тусгаарлагдах, халамж хамгаалалгүй үлдэх, амь насаа алдах</p>		

ГАМШГИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Эрсдэл, эмзэг байдал	Аюулд өртсөн тохиолдолд нэн даруй хийх зүйл	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
2. Гал түймэр		
<ul style="list-style-type: none"> Цахилгааны утас, залгуур, унтраалгын утас шалбарч, ил гарсан байх Амархан шатах эд зүйл цахилгаан хэрэгсэлтэй ойр байх Нэг залгуураас олон цахилгаан хэрэгслийг замбараагүй залгах Хийн зуухыг зааврын дагуу зөв хэрэглэхгүй байх Аврах гарцыг заасан тэмдэг тэмдэглэгээг байрлуулаагүй байх Аврах гарцын зам, хаалга чөлөөтэй биш байх Цонхнууд төмөр тороор бэхлэгдсэн, хүн гадагш гарах боломжгүй байх Галын хоргүй байх Галын хор хангалттай хэмжээгээр байхгүй байх Хүүхдийг гэрт нь цоожлон, ганцааранг нь үлдээх 	<ul style="list-style-type: none"> Галын талаар холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэх Бага хэмжээний галыг унтраах Бусдаас тусламж хүсэх Галаас аль болох хурдан холдох Хүүхдүүдийг аюулгүй газарт аваачин, тайвшруулах Хамт байсан хүмүүсээ бүртгэх Цахилгаан хэрэгслийг салгах Хүн шатаж байвал хэвтүүлэн, амархан шатахгүй зүйл (бүтээлэг гэх мэт) нөмөргөх байдлаар галыг дарж унтраах Галын машин ирэх замыг чөлөөлөх Галын машиныг тосон чиглүүлэх 	<ul style="list-style-type: none"> Цахилгааны аюулгүй байдлыг шалгаж хэвших, гэмтэл илэрсэн даруй мэргэжлийн хүнээр засуулах Халуун тогоо, буцламгай зүйл, гал гаргах хэрэгслийг хүүхдээс хол байлгах Амархан шатах материал тухайлбал газ, хийн бодис гэх мэт зүйлийг галаас хол байлгах Гал гарсан талаар мэдэгдэх утасны дугаарыг хүүхдэд тогтоолгох Галын аюулын тухай, гал унтраах сургалтыг тогтмол зохион байгуулах Галын хор ашиглан бага хэмжээний гал унтраах арга техникт хүмүүсийг сургах Цахилгааны автомат шитийг хэрэглээндээ тохируулан тавих Галын аюулаас урьдчилан сэргийлэх, хохирол багатай давах ардын арга ухаанд суралцах, сурталчлах
<p>Гал түймрийн аюулд өртсөн хүүхдэд дараах эрсдэл учирч болзошгүй: Түлэгдэх, угаартах, гэмтэх, бэртэх, хөгжлийн бэрхшээлтэй болох, төөрөх, сэтгэлийн хямрал, цочролд орох, эд хогшил нь шатаж эдийн засгийн хохирол амсах, амь насаа алдах гэх мэт</p>		

ГАМШГИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Эрсдэл, эмзэг байдал	Аюулд өртсөн тохиолдолд нэн даруй хийх зүйл	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
3. Хүчтэй цасан болон шороон шуурга		
<ul style="list-style-type: none"> • Хаалга, цонх онгорхой, бэхэлгээгүй байх • Цонхны шил цуурсан, хагарсан байх • Хүүхэд дулаан хувцаслаагүй байх • Хүүхдийг ганцааранг нь гадагш гаргах • Хүүхдийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулах (хурдан морины уралдаан) • Бүрэн бус машин техникээр хүүхдийг тээвэрлэх • Аврах, тусламж үзүүлэх байгууллага, хүмүүсийн утасны дугаарыг мэдэхгүй байх • Өөртөө болон бусдад туслах аргыг мэдэхгүй байх • Шат, шал, довжоо, замыг хүн халтирч гэмтэх материалаар хийсэн байх 	<ul style="list-style-type: none"> • Цахилгаан хэрэгслээ салгах • Биед эвтэй, хөдлөхөд чөлөөтэй, дулаан хувцас өмсөх • Төөрсөн үед тухайн газраасаа холдолгүй нөмөр газар бараадан суух, • Салхи тогтохыг хүлээх • Осгохгүйн тулд хөдөлгөөнтэй байх, унтахгүйг хичээх • Бага, насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах 	<ul style="list-style-type: none"> • Цаг агаарын мэдээг өдөр тутмын амьдралдаа хэрэглэх • Хоол хүнс, ус, түлш, дулаан хувцас зэргийг бэлтгэх • Гэр сууцаа хүчтэй салхи шуурганаас хамгаалах даруулга, тэнг хийх • Шуургатай өдөр хүүхдийг малд болон хол замд явуулахгүй байх • Өөртөө болон бусдад туслах талаар сургалтыг тогтмол зохион байгуулах • Аврах, тусламж үзүүлэх байгууллага, хүмүүсийн утасны дугаарыг хүүхдэд тогтоолгох • Бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд энгэрийн тэмдэг зүүх • Хүчтэй цасан, шороон шуурганаас хамгаалах ардын арга ухаанд суралцах, сурталчлах
<p>Хүчтэй цасан болон шороон шуурганд өртсөн хүүхдэд дараах эрсдэл учирч болзошгүй: Даарах, осгох, хөлдөх, гэмтэж бэртэх, хөгжлийн бэрхшээлтэй болох, төөрөх, амь насаа алдах</p>		

ГАМШГИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Эрсдэл, эмзэг байдал	Аюулд өртсөн тохиолдолд нэн даруй хийх зүйл	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
4. Зуд		
<ul style="list-style-type: none"> • Өвөлжилтийн бэлтгэлээ хангаагүй байх • Цонх, хаалгаа сайн дулаалаагүй байх • Хангалттай хүнс, түлш нөөцлөөгүй байх • Орон байр, байгууллагынхаа дулааны урсгал засварыг цаг хугацаанд нь хийгээгүй • Зудын гамшгийн тухай, бэлэн байдлыг хэрхэн хангах мэдлэг, туршлагагүй байх • Хүүхдэд учрах сэтгэл санааны болон биемахбодын хямралын талаар мэдлэггүй байх • Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд зудын үед хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаагүй байх 	<ul style="list-style-type: none"> • Дулаан хувцаслах • Замд гарахаар бол хаашаа, хэнтэй явж байгаагаа бусдад заавал мэдэгдэх • Цасанд боогдсон тохиолдолд цас ухаж нүх бэлтгэн хоргодох • Нөмөр газар бараадах • Үзэгдэх орчин хязгаарлагдмал үед замд явж байгаа бол хөдөлгөөнөө зогсоох • Бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах • Малаа бэлчээхгүй, дулаан хашаа, саравч, хороонд тэжээх • Малаа нэмнэх • Малдаа хүчит өвс тэжээл өгөх • Хүүхэд, насанд хүрэгчдэд сэтгэлийн дэм өгөх 	<ul style="list-style-type: none"> • Өвс тэжээл, түлш, хүнсээ хангалттай нөөцлөх • Цаг агаарын мэдээг өдөр тутмын амьдралдаа хэрэглэх • Сум, баг, айл хөрштэйгээ холбоо барих, хэл өгөх талаар урьдчилан тохирох • Цас цэвэрлэх, зам гаргах багаж хэрэгсэл бэлтгэх • Отроор явсан, цасанд боогдсон эцэг эх, гэр бүлтэйгээ харилцах боломжийг хүүхдэд олгох үүднээс шаардлагатай арга хэмжээг авах • Багш, нийгмийн ажилтан хүүхдүүдтэй дотно байж, зөвлөгөө, мэдээлэл өгөх • Бие биедээ сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх чадварт хүүхдүүдийг сургах • Цасанд боогдсоноос сургуульдаа цагтаа ирээгүй хүүхдүүдэд хичээлийн хоцрогдол нөхөх хөтөлбөр боловсруулах
<p>Зудын гамшигт өртсөн хүүхдэд дараах эрсдэл учирч болзошгүй: Даарах, осгох, хөлдөх, гэр бүлтэйгээ харилцаагүй болох, өвдөх, сэтгэл санааны хямрал, цочролд орох, хүчирхийлэлд өртөх, сурлагаар хоцрогдох, сургууль завсардах, амь насаа алдах</p>		

ГАМШГИЙН АЮУЛААС

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Эрсдэл, эмзэг байдал	Аюулд өртсөн тохиолдолд нэн даруй хийх зүйл	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
5. Үер ус		
<ul style="list-style-type: none"> Хүүхдийг гол, тогтоол ус, цөөрмийн ойролцоо харж асрах хүнгүй тоглуулах Үерийн аюултай газар амьдрах Үерээс хамгаалах далан, суваг, шуудуугүй байх Үерийн үед эрүүл мэнд, эд хогшил, амь насаа аврах талаар мэдлэггүй байх 	<ul style="list-style-type: none"> Дуу цахилгаантай бороотой үед гар утсаа унтраах Аянга цахилгаанаас сэргийлж өндөр шон, мод зэргээс холдох Аянга буух аюултай тул монгол гэрийн хаалга голлон суухгүй байх Усны гутал, дулаан хувцас өмсөх Цахилгаан хэрэгслийг салгах Аль болох өндөрлөг газарт гарах Эд зүйлээ усны түвшнээс дээш, өндөр газарт тавих Чухал бичиг баримтаа усанд норохоос хамгаалах Тусламж дуудах Бага насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах 	<ul style="list-style-type: none"> Үер усны сэрэмжлүүлэг мэдээллийг өдөр тутмын амьдралдаа хэрэглэх Усархаг бороотой үед гадагш гарахгүй байх Үерийн аюултай бүс нутгаас нүүх Үерээс хамгаалах далан, суваг, шуудуу барих Үер усны аюулын талаар хүүхдэд ойлгомжтой байдлаар тайлбарлах, сануулах Анхан шатны тусламж үзүүлэх сургалт дадлагыг тогмол зохион байгуулах Үерээс хамгаалах ардын арга ухаанд суралцах, сурталчлах
<p>Үер усны аюулд өртсөн үед хүүхдэд дараах эрсдэл учирч болзошгүй: Урсах, живэх, гэмтэж бэртэх, хөгжлийн бэрхшээлтэй болох, орон гэр, эд хогшлоо алдах, гэр бүлийнхнээ алдах, тэднээсээ төөрөх, сэтгэл санааны хямрал цочролд орох, хүчирхийлэлд өртөх, амь насаа алдах</p>		



СУРГУУЛИЙН ОРЧИНД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖИШЭЭ

Заавар: Доор үзүүлсэн загварын дагуу асуулт тус бүрт түүний ард буй “Тийм”, “Үгүй”, “Зарим” гэсэн гурван хариултын аль тохироход нь “√” тэмдэг тавих ба шаардлагатай бол тайлбар бичнэ. Гурван хариултаас тохирохыг сонгохдоо тухайн асуултын дагуу нөхцөл байдал ямар буйг ажиглах, харах, ярилцах, бичиг баримтыг судалж шинжлэх зэрэг аргыг хэрэглэнэ.

Санамж: Тухайн эд зүйл аюултай байгаа эсэхийг үнэлэхийн тулд харах, ажиглахдаа болгоомжтой байх нь зүйтэй. Жишээ нь цахилгааны утас шалбарч ил гарсныг илрүүлсэн бол гараараа барихгүй байх гэх мэт.

№	Эрсдэл	Тийм	Үгүй	Зарим	Тайлбар
Сургуулийн дотоод орчин					
1	Сургуулийн гол болон бусад хаалга гадагшаа онгойдог уу?				
2	Анги танхимын хаалгууд гадагшаа онгойдог уу?				
3	Сургуулийн анги, танхимын цонхнууд төмөр хаалтгүй юу?				
4	Сургуулийн гадна орчин хангалттай гэрэлтүүлэгтэй юу?				
5	Гол хаалганы ойролцоо хагарах шилэн эдлэл, цом зэргийг байрлуулаагүй, талбай нь аюулгүй, чөлөөтэй юу?				
6	Том, хүнд тавилгыг хананд бэхэлж хөдөлгөөнгүй, аюулгүй болгосон уу?				
7	Сургуулийн аврах гарц, хаалгууд чөлөөтэй, гарахад саадгүй байна уу?				
8	Аврах гарцыг заасан тэмдэг, тэмдэглэгээг хангалттай, ойлгомжтой байрлуулсан уу?				
9	Гал түймрийн үед хэрэглэх багаж хэрэгсэл бүрэн, зохих газраа байна уу?				
10	Гал унтраагуур хангалттай байна уу?				
11	Гал унтраагуур аюулгүй, зөв байрласан байна уу?				
12	Гал унтраагуур хэвийн ажиллаж байна уу?				

№	Эрсдэл	Тийм	Үгүй	Зарим	Тайлбар
13	Сургуулийн дулаан, сантехникийн шугам аюулгүй байна уу?				
14	Цахилгааны утас шалбараагүй, ил гараагүй байна уу?				
15	Залгуур эвдэрч унжаагүй, утас нь ил гараагүй байна уу?				
16	Амархан шатдаг материал, хэрэгсэл цахилгаан хэрэгслээс хол байна уу?				
17	Цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг байнга шалгадаг уу?				
18	Сургуулийн цайны газар хийн зуух хэрэглэдэггүй юу?				
19	Анги танхимын цонх дулаалгатай юу?				
20	Сургуулийн коридор, үүдний талбай нь хүн халтирч унахааргүй юу?				
21	Анги, танхим, коридор, шат, хаалга зэрэгт аюулгүйн гарцын тэмдэг тэмдэглэгээ байна уу?				
22	Бусад (доош цувуулан бичнэ)				
Сургуулийн гадаад орчин					
1	Сургуулийн орчинд ойрхон авто зам байдаг уу?				
2	Явган хүний гарцын гэрэл, тэмдэглэгээтэй юу?				
3	Зам хурд саагчтай юу?				
4	Огцом эргэлттэй зам байгаа юу?				
5	Явган хүний зам байгаа юу?				
6	Зам гэрэлтүүлэгтэй юу?				
7	Сургуулийн орчинд гүнзгий гуу жалга байгаа юу?				
8	Тэнэмэл нохой ихтэй юу?				
9	Сургуулийн ойр орчинд таглаагүй бохирын нүх, шугам байгаа юу?				
10	Шатахуун түгээгүүр ойрхон байрладаг уу?				
11	Архи тамхи зардаг мухлаг, дэлгүүр ойр байрладаг уу?				
12	Хичээлийн байр, дотуур байрны хоорондын зай хол уу?				

№	Эрсдэл	Тийм	Үгүй	Зарим	Тайлбар
13	Сургууль эрэгтэй, эмэгтэй хүнд тус тусад нь зориулсан бие засах газартай юу?				
14	Бие засах газар гэрэлтүүлэгтэй юу?				
15	Бусад (доош цувуулан бичнэ)				
Гамшгийн эрсдэлийг бууруулах, хамгаалах чадавхийн үнэлгээ					
1	Хүүхдэд зориулсан гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөр бий юу?				
2	Уг хөтөлбөрөөр сурагчдад зориулсан сургалт, семинар, дадлага сургуулилт зохион байгуулдаг уу? Хэр зэрэг тогтмол зохион байгуулдаг вэ?				
3	Хүүхдүүд ямар нэгэн гамшгаас өөрийгөө хамгаалах, бусдад туслах чадвартай юу?				
4	Багш, ажилтнуудад зориулсан гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөр бий юу?				
5	Уг хөтөлбөрөөр багш, ажилтнуудад зориулсан сургалт, семинар, дадлага сургуулилт зохион байгуулдаг уу? Хэр зэрэг тогтмол вэ?				
6	Багш, ажилтнууд ямар нэгэн гамшгаас өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай юу?				
7	Гамшгийн улмаас шоконд орсон, сэтгэл санаа нь зовуурилсан хүүхдэд сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх чадварыг сурагч, багш, ажилтнууд эзэмшсэн үү?				
8	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллах сурагчдын сайн дурын бүлгүүд бий юу?				
9	Сайн дурын бүлгүүд байдаг бол тэдний үйл ажиллагааг хангалттай чиглүүлж чаддаг уу?				
10	Бусад (доош цувуулан бичнэ)				

2

3

4

5

6

7

8

9

№	Эрсдэл	Тийм	Үгүй	Зарим	Тайлбар
Гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт, нөөц					
1	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө бий юу?				
2	Гамшгийн үед хэн, ямар үүрэг гүйцэтгэх ёстойг шийдсэн үү?				
3	Гамшгийн үед гүйцэтгэх үүргээ багш, ажилтнууд болон хүүхдүүд мэдэж байгаа юу?				
4	Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр мэргэжлийн болон бусад байгууллагатай хамтран ажилладаг уу?				
5	Гал унтраах хэрэгсэл, галын хор хангалттай бий юу?				
6	Нэн шаардлагатай эм, хэрэгсэл бүхий анхны тусламжийн хайрцаг хангалттай байгаа юу?				
7	Гамшгийн үед хүүхдэд ээлтэй орон зай үүсгэх, сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулахад хэрэглэх гэр, майхан, ширээ сандал гэх мэт зүйл бий юу?				
8	Хүүхдэд ээлтэй орон зай бүрдүүлэхэд шаардлагатай эд зүйл нөөцөлсөн үү?				
9	Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах зардлыг төсөвт тусгасан уу?				
10	Бусад (доош цувуулан бичнэ)				

ТЭМДЭГЛЭЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулахад яагаад хүүхдийн оролцоог хангах ёстой вэ?

- Нийгэм, олон нийтийн нэг гишүүн, идэвхтэй иргэний хувьд хүүхэд өөртөө болон үе тэнгийнхэндээ тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг олоход туршлага, мэдлэг, мэдээлэлдээ тулгуурлан үзэл бодол, саналаа хэлэх эрхтэй. Ингэснээр томчууд хүүхдийн төлөө үр бүтээлтэй ажиллаж, нөөцийг зөв хуваарилах боломж бүрддэг.
- Хүүхэд эцэг эх, асран хамгаалагчаасаа хол сургууль, цэцэрлэгтээ байх үед байгалийн гамшиг тохиолдвол хүүхдийг хамгаалах насанд хүрэгчдийн нөөц хүрэлцэхгүй байж болзошгүй тул гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоо чухал.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоо гэж юу вэ?

- Эргэн тойрны нөхцөл, бодит байдлын эрсдэлийг тооцох, тулгамдсан асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх арга замын талаар саналаа хэлэх, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах
- Үзэл бодлоо илэрхийлэх
- Бусад хүмүүстэй эерэгээр харилцах чадварууд бүрдэх, хэрэгжих

Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхэд юу хийж чадах вэ?

Сургууль, орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх, хянахад хүүхдүүдийг оролцуулж байвал тэд өөрийгөө хамгаалж, бусдад туслах мэдлэг, чадвартай болохоос гадна гамшгийн үед болон дараа сэргээн босгох үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах боломжтой болно.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүүхдүүд ямар хэлбэрээр оролцох боломжтой байдгийг доорх жишээнээс харна уу.

Гамшгийн өмнө:	Гамшгийн үед болон дараа:
<ul style="list-style-type: none"> • Үеийнхээ болон өөрөөсөө дүү хүүхдүүдийг сургах сургалтын хөтөлбөр боловсруулж чадна. • Уг сургалтын хөтөлбөрөөр үеийнхэндээ болон өөрөөсөө дүү хүүхдүүдэд сургалт хийж чадна. • Гамшгийн эрдэлээс өөрийгөө хамгаалах, бусдад туслах мэдлэг, чадвар эзэмшиж чадна. • Сэтгэлзүйн хийгээд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх аргад суралцаж чадна. • Бага насны хүүхдүүдийг сургах үүрэг бүхий хүүхдүүдийг дэмжиж чадна. 	<ul style="list-style-type: none"> • Өөрөөсөө дүү хүүхдүүдийг хамгаалж, асарч чадна. • Хүүхдүүдэд зориулсан тоглоом хийж чадна. • Гэр бүлийн гишүүдээ алдсан гэх мэт сэтгэл санааны хувьд хүнд байгаа хүүхэдтэй тоглож, тэдэнд тусалж чадна. • Гэмтэж бэртсэн хүмүүсийг асарч чадна. • Хүүхдүүдэд сэтгэлзүйн болон эмнэлгийн анхны тусламж үзүүлж чадна. • Хүнс цуглуулах, хуваарилах, хоол бэлтгэх, цэвэрлэх ажилд тусалж чадна.

Хүүхдэд ээлтэй орон зай гэж юу вэ?

Гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, тулгарч буй эрсдэлийг даван туулах чадвартай болоход нь туслах аливаа үйл ажиллагааг зохион байгуулах аюулгүй, найдвартай орчныг хүүхдэд ээлтэй орон зай гэж нэрлэдэг. Энд хүүхдүүд амрах, бие биетэйгээ тоглох, ярилцах, сэтгэл санаагаа сэргээх, сурах зэргээр хэвийн амьдралаа үргэлжлүүлж болно.

Хүүхдэд ээлтэй орон зайг хаана байгуулах вэ?

Сургууль, олон нийтийн төв, гэр, майхан, асар зэргийг ашиглан хүүхдэд ээлтэй орон зай байгуулж болно. Хамгийн гол нь хүүхэд аюулгүй байгаага мэдэрсэн орчин байх нь чухал. Хүүхдэд ээлтэй орон зай бүрдүүлэхэд дараах зүйлийг хамгийн түрүүнд анхаарна:

- Хүүхдүүд, тэдний гэр бүл, бусад хүн олж очиход амар байх
- Хангалттай зай талбайтай байх
- Аюулгүй, тэгш, хуурай газарт байрласан байх
- Ус, ариун цэврийн байгууламжтай ойр байх
- Хүмүүст нээлттэй байх.

Хүүхдэд ээлтэй орон зайд хэн ажиллаж болох вэ?

Хүүхдэд ээлтэй орон зайд багш, нийгмийн ажилтан, халамжийн ажилтан, сэтгэлзүйч, эмч зэрэг хүмүүс ажиллаж болно. Эдгээр хүнийг хүүхэд хамгааллын чиглэлээр өмнө нь сургаж бэлтгэсэн байх нь тун чухал.

Хүүхдэд ээлтэй орон зайд ямар үйл ажиллагаа явуулах вэ?

Хүүхдэд ээлтэй орон зайд буй хүүхдүүдтэй ярилцсаны үндсэн дээр өдөр тутмын ажлын хуваарь гаргаж болно.

Аливаа үйл ажиллагаа хийхдээ дараах хэлбэрийг харгалзан үзээрэй:

- Төрөл бүрийн үйл ажиллагааг хүүхдүүдийн нас насанд нь тохируулан явуулах
- Бүх хүүхдийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах
- Хүүхдүүдээс гадна тэдний гэр бүл, асран хамгаалагчдыг оролцуулсан үйл ажиллагааг хийх.

Үйл ажиллагааны жишээ

Үйл ажиллагаа	Зорилго	Хэрэгсэл	Хэрхэн хийх вэ?
Жүжиг	<ul style="list-style-type: none"> • Шийдвэр гаргах • Идэвхийг сэргээх • Хамтрах, хуваалцах чадвар хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Хүүхэлдэй • Хуруун хүүхэлдэй • Жүжгийн бусад хэрэгсэл 	<ul style="list-style-type: none"> • Хүүхдүүдээр өөрсдөөр нь дэглүүлэх • Хүүхдүүд өөрсдөө хэрэгслээ сонгох
Сэтгэхүй хөгжүүлэх тоглоом	<ul style="list-style-type: none"> • Мэдрэмж, саналаа хуваалцах • Туршилт явуулах 	<ul style="list-style-type: none"> • Зураг, бичгийн хэрэгсэл • Эвлүүлдэг шоо • Хүүхэлдэй 	<ul style="list-style-type: none"> • Сэдэв өгөх (Гэр бүлээрээ хийдэг байсан зүйл) гэх мэт

Үйл ажиллагаа	Зорилго	Хэрэгсэл	Хэрхэн хийх вэ?
Ярилцлага	<ul style="list-style-type: none"> Мэдрэмж, бодол санаагаа илэрхийлэх Сонсох, ярих чадвараа хөгжүүлэх Ёс заншлаас суралцах 	Ном, үлгэр домог	<ul style="list-style-type: none"> Ярилцах сэдвийн талаар хүүхдүүдээс асуух Тэдний дуртай ном, үлгэр домгийг сонгон ярилцах
Бие бялдрын тоглоом	<ul style="list-style-type: none"> Биеийн тэнцвэрээ хөгжүүлэх Өөртөө итгэж сурах 	Дээс, бөмбөг, бусад спортын хэрэгсэл	Тоглоомоо чөлөөтэй сонгож тоглох
Боловсрол	<ul style="list-style-type: none"> Академик чадвараа хөгжүүлэх 	Сурах бичиг гэх мэт	Тодорхой хичээлүүдийг үргэлжлүүлэн заах

Хүүхдэд ээлтэй орон зайд юу юу байх ёстой вэ?

- Бичиг баримт (Хүүхдүүдийн мэдээлэл, бүртгэл, ажилтнуудын ёсзүйн дүрэм, хүүхэд хамгаалын бодлого, явуулах үйл ажиллагааны чиглэл гэх мэт)
- Тоглоом, хэрэгсэл (Хүүхэддэй, бөмбөг, дээс, шатар, даам, өрж эвлүүлдэг тоглоомууд гэх мэт аль болох олуулаа тоглохыг дэмжсэн тоглоом, хэрэгслүүд)
- Ном, бичгийн хэрэгсэл (Нас, насны хүүхэд уншихад тохиромжтой номууд, зургийн хэрэгсэл, дэвтэр, харандаа, үзэг, самбар гэх мэт)
- Ариун цэврийн бүрдэл (Алчуур, саван, сойз, оо, угаалгын нунтаг гэх мэт)
- Ундны усны нөөц
- Анхны тусламжийн хэрэгсэл

Хүүхдэд ээлтэй орон зайд байх эд зүйл (жишээ)

Хамгийн багадаа 20 хүүхдэд хүрэлцэх эд зүйл хүүхдэд ээлтэй орон зайд байхаар бэлтгэнэ. Доор үзүүлсэн жагсаалт нь жишээ болохыг анхаарна уу.

№	Нэр төрөл	Тоо
1	Зургийн дэвтэр	5
2	Өнгийн харандаа	5
3	Цавуу	5
4	Маркер	1
5	Үзэг	5
6	Самбар	1
7	Баллуур	5
8	Ном (багц)	3
9	Дасгалын дэвтэр	5
10	Шугам	5
11	Ханын цаг	1
12	Цаас А4	1
13	Цаас А3	1
14	Харандаа үзүүрлэгч	5
15	Дээс	2
16	Лего тоглоом	2
17	Шагай (аль болох олон)	1

№	Нэр төрөл	Тоо
18	Зөөлөн жижиг бөмбөг	3
19	Гар бөмбөг	1
20	Хувин	1
21	Түмпэн	1
22	Аяга	20
23	Ус шүүгч	1
24	Усны сав	1
25	Толь	1
26	Сам	20
27	Гар болон эдийн саван	10
28	Угаалгын нунтаг	1
29	Алчуур	20
30	Галын хор	1
31	Зөөлөвч дэвсгэр	2
32	Гар насос	1
33	Бүртгэлийн хуудас	-
34	Тэмдэглэлийн дэвтэр	1

ТЭМДЭГЛЭЛ

Яагаад боловсрол чухал гэж?

Гамшгийн нөхцөл байдалд байгаа ч гэсэн хүүхэд бүр боловсрол эзэмших, үргэлжлүүлэн суралцах эрхтэй. Учир нь ялангуяа гамшиг удаан хугацаанд үргэлжилсэн тохиолдолд хүүхдийн сурч боловсрох эрх хязгаарлагдах, зөрчигдөх ёсгүй бөгөөд боловсролыг үргэлжлүүлэн олгох нь хүүхэд хамгаалал, боловсролын байгууллагын нэн тэргүүний үйл ажиллагаа байх ёстой.

Түүнээс гадна гамшгийн үеийн боловсрол нь хүүхэд хамгааллын нэг хэлбэр бөгөөд хүүхдэд нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг болдог.

Гамшгийн үед боловсролын үйл ажиллагаа явуулахад юу анхаарах вэ?

- Хүүхдийн тоог нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр нь ангилж гаргах, түр хичээллэх анги танхим, багш, сургалтын хэрэгцээг тооцох, үнэлгээ хийх
- Түр сургууль барьж байгуулах
- Сургалтад хэрэгцээтэй материал хэрэгслээр хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, бусад сургалтад дайчлах багш, хүний нөөцийг шийдэх
- Сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагааг зохион байгуулах, урлаг, спортын ажлуудыг төлөвлөх.

Дээрх бүх үйл ажиллагаанд хүүхэд залуус, олон нийтийг оролцуулахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлээсээ төөрсөн хүүхдийн асуудлыг нэн түрүүнд анхаарах ёстой.

Сургалтын үйл ажиллагааг аюулгүй орчинд сайтар төлөвлөн, зохион байгуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй болон үндэсний цөөнх хүүхдүүдийг хамтад нь оролцуулах боломжийг дэмжинэ.

Хэн боловсрол олгох вэ?

Гамшгийн үед боловсролын үйл ажиллагааг багш, сургагдсан сайн дурын ажилтан, ахмад багш нар, үе тэнгийн хүүхэд залуус зохион байгуулж явуулна. Гамшгийн үед сургуулиудын барилга нурах, багш, ажилтнууд хүрэлцэхгүй байх зэрэг асуудал үүсдэг тул гамшгийн үеийн боловсролд олон нийтийн болон хүүхдийн оролцоо чухал үүрэгтэй.

Гамшгийн үед боловсролын үйл ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулахад бэлтгэх үүднээс тайван цагт багш, ажилтан, сайн дурын ажилтнууд, насанд хүрэгчдэд албан бус сургалтаар дамжуулан хүүхэдтэй ажиллах ур чадварт сургах шаардлагатай. Жишээлбэл, хүүхэдтэй харилцах, ярилцах, тоглоомын аргаар дамжуулан хүүхдэд гамшгийн нөхцөл байдлыг даван туулах чадвар олгох гэх мэт.



Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл гэж юу вэ?

Хүйсийн ялгаа, хүч, чадварын тэнцвэргүй байдлаас үүдэн бие махбодын, бэлгийн болон нийгэм-сэтгэлзүйн шинжтэй хүчирхийллийг жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл гэнэ. Үүнд хүчирхийллийн дараах төрөл багтдаг:

- Бие махбодын хүчирхийлэл (зодуур, бэлгийн хүчирхийлэл гэх мэт)
- Гэр бүлийн хүчирхийлэл (гэр бүлийн хэн нэг гишүүн бусаддаа дарамт хүчирхийлэл үзүүлэх гэх мэт)
- Нийгэм-эдийн засгийн хүчирхийлэл (санхүүгийн хувьд хараат байдалд оруулах, хэрэгцээт зүйлээр нь байнга гачигдуулах гэх мэт)
- Сэтгэлзүйн дарамт хүчирхийлэл (гутаан доромжлох, сэтгэл санааны дарамтад оруулах, гэртээ хорих, тусгаарлах гэх мэт).

Яагаад гамшгийн үед жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд анхаарах ёстой вэ?

Гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хүчирхийлэлд өртөх нь эрс ихсэх хандлагатай болдог. Зөвхөн иргэдийн зүгээс бус хүмүүнлэгийн тусламж үзүүлж буй байгууллага, хүмүүс хүүхдийг хүчирхийлсэн тохиолдол байдаг.

Багш, нийгмийн ажилтан юу хийх вэ?

Эхлээд доорх кейсийг уншаарай.

Кейс

Би 15 настай, 10 дугаар ангид сурдаг. Энэ жил манай нутаг цас ихтэй, зуд болж аав маань отроор явсан болохоор уулзаагүй удаж байна. Би сумын төвд 3 дүүгийнхээ хамт амьдардаг. Ер нь дүү нараа хараад бага гэрээр амьдарна гэдэг хэцүү. Хааяа сумын төвд байдаг хамаатны ах ирж биднийг эргэж тойрдог боловч би түүнээс их айдаг. Учир нь тэр намайг ганцаараа байхад хөхөнд хүрээд, хормой сөхөөд байдаг. Хүнд хэлнэ гэхээр “Чи юун их юм боддог юм. Яагаа ч үгүй байхад их юм бодлоо” гэх юм. Ийм юм байж болохгүй гэдгийг мэдээд байгаа хэрнээ аавдаа хэлэхээс санаа зовоод байх юм. Багшид хэлбэл намайг ойлгож туслах болов уу.

Иймэрхүү асуудал тохиолдоод яахаа мэдэхгүй байгаа хүүхдүүд байж болно. Тиймээс багш та бүхэн сурагчидтайгаа ярилцаж, зарим үед ганцаарчлан уулзах хэрэгтэй. Хүүхдүүдийн итгэлийг хүлээж чадвал тэд санаа зовоож буй зүйлээ нуулгүй ярьж, тусламж авч чадна. Ингэхийн тулд тэдний нууцыг хадгалж, шаардлагатай бол нийгмийн ажилтантай хамтран туслаарай.

Багш, нийгмийн ажилтан жендэрээс үүдэлтэй хүчирхийллээс хүүхдийг хамгаалахын тулд дараах гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

1) Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх: Энэ нь хүүхэд хүчирхийлэл, дарамтад өртөж болзошгүй шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, арилгах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг багтаадаг. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд дараах зүйлийг анхаараарай:

- Хүүхэд хүчирхийлэл, дарамтад өртөх эрсдэл, нөхцөл байдлыг илрүүлэхдээ ажиглах, ярилцах, хэлэлцүүлэг хийх, судалгаа хийх, санал хүсэлтийн хайрцаг ажиллуулах гэх мэт аргыг ашиглах боломжтой.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд ямар шинж тэмдгүүд илэрдэг талаар багш, нийгмийн ажилтнууд мэддэг байх ёстой.
- Сургуулийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг боловсруулах, мөрдөх, хүүхдүүд, эцэг эх, багш, ажилтан, иргэдэд уг бодлогыг сурталчлах, ойлгуулах ажлыг хийх нь зүйтэй.
- Хүчирхийллийг үл тэвчих орчныг бий болгох, хүүхдүүд үзэл бодол, санал гомдлоо нээлттэй хэлэх боломжийг олгох нь зохимжтой.

2) Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх: Нэн түрүүнд хүүхдийн амь нас, бие махбод, сэтгэл санаанд ноцтой хохирол үзүүлж байгаа аюул эрсдэлийг таслан зогсоох, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ. Энэ ажлын хүрээнд дараах зүйлийг анхаараарай:

- Хүүхэд хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд кейс нээн, хүүхэд хамгааллын хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.
- Гамшиг, онцгой байдлын үед жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх байгууллага, мэргэжилтний талаар мэдээлэл цуглуулж, хамтарсан сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах шаардлагатай.

3) Нөхөн сэргээх: Энэхүү үйлчилгээ нь хямрал, бэрхшээлийг даван туулж байгаа хүүхдэд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, итгэл найдвараа олоход нь туслах, шинэ орчинд дасан зохицоход нь туслах бүхий л үйл ажиллагааг багтаана. Хүүхдэд үзүүлэх дэмжлэг нь түүнтэй харилцах харилцаа, хандлагаас эхэлдэг. Иймд хүүхэдтэй харилцаж байгаа хэн бүхэн хүүхдэд сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэх чадвартай байх хэрэгтэй. Хүүхдэд сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэхдээ дараах зүйлийг анхаарна:


- Хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдэд илрэх шинж тэмдэг, сэтгэлийн зовуурьтай хүүхдийн гаргах нийтлэг зан авирыг таньж мэдэх
- Хүүхэд ямар нөхцөл байдалд байгаа, нэн тэргүүний хэрэгцээ юу болох, түүнд ямар аюул эрсдэл тохиолдож байгааг тодорхойлох
- Хүүхдийн өгч байгаа мэдээлэлд анхаарал хандуулан, түүний яриаг таслахгүй, шүүж цэгнэлгүй чин сэтгэлээсээ сонсох
- Яриаг дэмжих үг хэллэг, үйлдлээр дамжуулан түүнийг ойлгож байгаагаа мэдэгдэх, тодруулах оновчтой асуулт асуух замаар шаардлагатай мэдээллийг авч, тайвшрахад нь туслах, бэрхшээлийг даван туулахад нь сэтгэлийн дэм өгөх
- Хүүхдийг шаардлагатай тусламж дэмжлэг, үйлчилгээнд холбох

Сургууль юу хийх ёстой вэ?

Гамшгийн үед хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон талын байгууллага, мэргэжилтнүүд, иргэд, олон нийт, хүүхдийн оролцоо чухал байдаг бөгөөд энд сургууль юу хийх ёстойг дурдъя:

- Хүүхдийг дарамт, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалах “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг боловсруулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь хүүхэд бүрийн аюул эрсдэлгүй орчинд сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд сургуулийн багш, ажилтан албан хаагч, эцэг эх, олон нийт хүмүүсийн анхаарах зүйлийг заасан баримт бичиг юм. Тодруулбал хүүхэд аюул эрсдэлд өртөхөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд ямар арга хэмжээг, хэн, яаж авах ёстой зэрэг үйл ажиллагааг бодлогод тусгасан байх ёстой.
- Бүх шатны боловсролын байгууллага гамшиг, онцгой байдлын үед гарах жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн талаар насны онцлогт тохирсон аргачлалаар хүүхдүүдэд тогтмол сургалт зохион байгуулах хэрэгтэй. Сургалтын агуулгад ямар ч үед хүүхдийн эрх хэвээр үйлчлэх, урьдчилан сэргийлэх болон тусламж шаардлагатай үед хэнд, яаж хандах талаар тодорхой оруулах нь зохимжтой.
- Хүүхдүүд сургууль дээрээ хүчирхийллийн эсрэг нэгдэн, бүлэг байгуулах, үе тэнгийнхнийхээ сургалт явуулах ажлыг дэмжин туслах хэрэгтэй.
- Гамшгийн үед хүүхэд эрхээ эдлэх, янз бүрийн хэлбэрийн хүчирхийллээс хамгаалагдах эрхийн талаар сургалт сурталчилгааны самбар, зөвлөмж, санамж гаргах ажлыг хийнэ.
- Гамшгаас өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлээр хүүхдүүд болон ажилтнуудад мэдлэг олгох сургалт, дадлага олгох ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг хянана.

ТЭМДЭГЛЭЛ



ТЭМДЭГЛЭЛ

Гамшгийн үед хүүхдэд тохиолдож болзошгүй хамгийн түгээмэл эрсдэлийн нэг нь эцэг эх, асран хамгаалагч, төрөл саднаасаа төөрөх явдал юм. Хүүхэд төөрөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хүүхдийн байгууллагын ажилтан бүр тодорхой мэдлэг, дадлагатай байх нь эрсдэлийг бууруулахад чухал нөлөөтэй.

Хүүхэд төөрөх ямар нөхцөл байж болох вэ?

- Гамшгийн үед эмх замбараагүй байдал үүсэх
- Эцэг эх, гэр бүл, асран хамгаалагч нь нас барах, сураггүй болох
- Эцэг эх, гэр бүл, асран хамгаалагч нь хоргодох байранд орох эсвэл нүүлгэн шилжүүлэх явцад төөрсөн, хаягдсан, салсан
- Хулгайлагдах буюу хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх
- Эцэг эх, асран хамгаалагч нь баривчлагдах, хоригдох
- Хорио цээрийн дэглэм тогтоох үед хүүхэд эцэг эх, гэр бүл, асран хамгаалагчаасаа тусдаа байх гэх мэт

Төөрсөн хүүхдэд хэрхэн туслах вэ?

- Төөрсөн хүүхдийг тайвшруулах, түүнд нөхцөл байдлыг ойлгомжтой тайлбарлах
- Хүүхэдтэй ойлгомжтой, тайван ярилцах
- Хүүхдүүд санал бодлоо хэлэх нээлттэй орчин бий болгох
- Хүүхдийг бүртгэх
- Шаардлагатай үед хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авах
- Хүчирхийллийг үл тэвчих орчин бий болгох, ялангуяа үе тэнгийн хүүхэд хоорондын хүчирхийллийг хүлээн зөвшөөрөхгүй байх
- Хүүхдийг хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллага, мэргэжилтнүүдтэй холбох

Төөрсөн хүүхдийг хэрхэн бүртгэх вэ?

- Хүүхэд тус бүрт бүртгэлийн дугаар өгөх
- Бүртгэлийн хуудас боловсруулан хэрэглэх (загварыг арын хуудаснаас үзнэ үү)
- Нэг айлын хүүхдүүдийг тус тусад нь бүртгэх
- Хүүхдийн зургийг бүртгэлтэй хавсаргах
- Хэвлэхдээ хүүхдийн зургийг танигдахуйц байхад анхаарах

**ЭЦЭГ ЭХ, ГЭР БҮЛ, АСРАН ХАМГААЛАГЧААСАА
ТӨӨРСӨН ХҮҮХДИЙГ БҮРТГЭХ МАЯГТ**

Байгууллагын нэр: _____

А. Хүүхдийн талаарх мэдээлэл:

Овог, нэр: _____

Дууддаг нэр: _____

Нас: _____

Хүйс: _____

Б. Хамтдаа байгаа төрсөн ах, эгч, дүү нарын талаарх мэдээлэл:

Төрсөн ах, эгч, дүүтэйгээ хамт байгаа эсэх Тийм Үгүй
(Тийм бол доорх хэсгийг бөглөнө.)

Овог, нэр _____

Дууддаг нэр: _____

Нас: _____

Хүйс: _____

В. Эцэг эх, гэр бүл, асран хамгаалагчийн талаарх мэдээлэл:

Эцгийн овог нэр: _____ Амьд Нас барсан Сураггүй

Эхийн овог нэр: _____ Амьд Нас барсан Сураггүй

Төөрөхөөс өмнө хүүхдийн амьдарч байсан газрын мэдээлэл, хэн, хэнтэйгээ амьдарч байсан, тэдэнтэй холбогдох утас:

Г. Хүүхэд гэр бүлээсээ хэрхэн төөрсөн талаарх мэдээлэл:

Төөрсөн огноо: _____ Төөрсөн газар, байршил: _____

Төөрсөн шалтгаан: _____

Гэр бүлээсээ төөрснөөс хойш очсон газрууд:

Д. Хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээлэл:

Ярилцлага хийсэн ажилтны овог, нэр, гарын үсэг:

Ярилцлага хийсэн огноо:

Бүртгэлтэй танилцсан хүүхдийн овог, нэр, гарын үсэг:

Бүртгэл хийхэд хамт байлцсан ажилтны овог, нэр, гарын үсэг:

Зуд болоход малчдын хүүхдүүд “Аав ээж хэр байгаа бол, мал сүрэг мэнд байгаа болов уу, цас их орж байгаа болов уу, зам хаагдсан болов уу, түлээ хангалттай байгаа болов уу, хэрвээ бүх малаа алдчихвал цаашдаа яаж амьдарна аа, надад зүсэлж өгсөн хурдан үрээ минь зүгээр байгаа даа” гэх мэтээр олон зүйлийг бодож, санаа зовж, шаналж байдаг.

Эсвэл гал гарах, газар хөдлөх гэх мэт гамшиг учрахад хүүхдүүд бие махбодын хувьд эрүүл саруул мэт байвч айж сандрах, өөрийгөө болсон явдалд буруутгах зэргээр сэтгэл санааны хувьд шаналж байх нь олонтаа.

Ийнхүү сэтгэл санаа нь таагүй, олон зүйлд санаа зовж, шаналж буй хүүхэд хичээлдээ анхаарлаа хандуулъя гэсэн ч чадахгүй бөгөөд улмаар хичээлдээ хоцрогдох, сурлага муудах, хичээлдээ сонирхолгүй болох, бүр цаашилбал сургууль завсардаж ч болзошгүй.

Тиймээс багш та бүхэн ямар нэгэн гамшиг тохиолдсон нөхцөлд бэртэж гэмтсэн зүйл байхгүй байна гээд хүүхдийг зүгээр орхих биш, ямар нэгэн хэвийн биш зан авир илэрвэл хүүхэдтэй ярилцан, сэтгэл санааг нь “эмчлээрэй”. Үүний тулд багш та бүхэнд дараах зүйлийг зөвлөмжилж байна.

6-14 НАСНЫ ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Юу болсныг ойлгохгүй байх эсвэл болсон явдалд эргэлзэж байна уу?

Сургуулийн насны хүүхдүүд, нэн ялангуяа 6-14 насныхан аливаа зүйл хоорондын уялдаа холбоог ойлгодог ч болсон явдлыг логиктой ойлгох чадвар дутмаг байдаг. Болсон явдалд барьц алдах бөгөөд хаа нэгтэйгээс ид шидтэн, эсвэл хүчтэн гарч ирээд бүх зүйлийг бий болгосон, эргээд байхгүй болгоно гэсэн “ид шидийн” бодол тээдэг учраас болсон явдлыг бүрэн дүүрэн ухаарахгүй. Энэ тохиолдолд болсон явдлыг тодорхой тайлбарлаж ойлгуулахгүй бол өөрийнхөө төсөөллөөр бодож, сэтгэж, ойлгоно.

Энэ тохиолдолд дараах байдлаар хүүхдэд туслаарай:

- Асуусан үед нь болсон явдлын талаар тодорхой тайлбарлаж, буруу ойлголтыг нь залруулна. Айлгахгүйн тулд болсон явдлыг хэт нарийвчлан ярих хэрэггүй. “Дахин хүчтэй хуй салхи болно гэж хүүхдүүд ярьж байгаа ч бид одоо аюулгүй газарт байгаа.” гэж хэлэх байдлаар хүүхдийг тайвшруулна.
- Асуух бүрт нь цааргалж дургүйцэхгүйгээр хариулж, гэр бүл нь аюулгүй байгааг дахин дахин хэлнэ.
- Цаашид юу болохыг хүүхдэд хэлнэ. Жишээ нь, сургуульд үргэлжлүүлэн сурах эсвэл хаана амьдрах талаар хүүхдэд ярина.
- Сургуулийн бүх хүүхэд, тэдний гэр бүлийг аюулгүй байлгах ажиллаж буй хүмүүс бий, хэрэгтэй үед тусламж авч болно гэдгийг хүүхдэд хэлж ойлгуулна.

Хүүхэд болсон явдалд өөрийгөө буруутгаж байна уу?

Хүүхдүүд болсон явдалд өөрийгөө буруутгах хандлага гаргаж болно. Тэд болсон явдлыг тохиолдохооргүйгээр өөрчлөх боломжтой байсан гэж бодно. Ийнхүү болсон явдалд өөрийгөө буруутгаж буйгээ хэнд ч хэлэхгүй байж болно.

Энэ тохиолдолд дараах байдлаар хүүхдэд туслаарай:

- Санаа зовж буйгаа хэлэх боломжийг хүүхдэд олгоно.
- Түүний буруугаас болж тийм зүйл тохиолдоогүй гэдгийг тайлбарлана.
- “Иймэрхүү аймшигт явдал тохиолдсоны дараа ихэнх хүүхэд, томчууд ч гэсэн “Юуг буруу хийчихэв ээ?” эсвэл “Ямар нэг зүйл хийх ёстой байсан юм?” гэж боддог. Энэ нь тэдний буруугаас тийм зүйл болсон гэсэн үг биш.
- “Чиний морь амьд үлдэх боломжгүй байсан, энэ чиний буруу биш шүү дээ” гэхчлэн хэлнэ.

Хүүхэд болсон явдлын талаар дахин дахин ярих эсвэл түүнийг дүрслэн тоглож байна уу?

Хүүхэд ямар нэгэн гамшиг, аймшигт зүйлийг нүдээр харж, биеэр туулсан нөхцөлд иймэрхүү зан авир нь гаргах нь хэвийн зүйл. Тиймээс энэ талаар ярих, дүрслэн тоглохыг нь зөвшөөрөх, тоглуулах эсвэл зуруулах зэргээр хандвал хүүхэд аяндаа айхаа болино.

Энэ тохиолдолд дараах байдлаар хүүхдэд туслаарай:

- “Юу болсон талаар чи их олон зураг зуржээ. Ийм зүйл болоход бүх хүүхэд ингэж олон зураг зурдаг.” гэж хүүхдэд тайлбарлаж болно.
- “Шинээр барих сургууль ямар байгаасай гэж, ямар байвал аюулгүй гэж бодож байгаагаа зурж болно шүү дээ.” гэж санал тавьж болно.

ӨСВӨР НАСНЫ (14-18 НАС) ХҮҮХДҮҮДЭД ТУСЛАХ ЗӨВЛӨМЖ

Болсон явдал дахин давтагдах вий гэхээс айх, түүнийг сануулах зүйлээс зайлсхийх

Болсон явдал дахин давтагдах вий гэж айх нь хэвийн зүйл бөгөөд аюулгүй гэдгийг мэдрэхэд цаг хугацаа шаардлагатай.

Энэ тохиолдолд дараах байдлаар хүүхдэд туслаарай:

- Болсон явдалтай холбоотой хүн, газар, дуу чимээ, үнэр, мэдрэмж, өдөр, цаг гэх мэт болсон явдлыг сануулах аймшигт зүйлийг тодорхойлоход хүүхдэд тусална. Болсон явдал болон түүнийг сануулах зүйл хоорондын ялгааг ярилцана. Ингэхдээ “Болсон явдал бодогдоод байвал гал гараагүй, би аюулгүй байна, би зүгээр л энэ талаар эргэн бодож байна гэж өөртөө хэлээрэй.” хэмээн тайлбарлаж болно.
- Болсон явдлыг эргэн сануулахгүйн үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгслээс хол байлгана.

Гэр бүл болон бусад хүмүүст санаа зовох

Өсвөр насны хүүхдүүд бусдын төлөө анхаарал хандуулах бөгөөд бусдад туслахын тулд зөв зүйл хийж чадаагүй хэмээн бодох хандлагатай.

Энэ тохиолдолд дараах байдлаар хүүхдэд туслаарай:

- Бусад хүнийг дэмжих гэсэн хүүхдийн санааг үргэлж сайшаах хэрэгтэй. Гэхдээ хэтэрхий их санаа зовж, ачаалал үүрэх ёсгүйг тайлбарлана.
- Сургуулийн талбайг цэвэрлэх, бусдад туслах хандив цуглуулах гэх мэт өсвөр насны хүүхдэд тохирсон зүйлийг тэдэнд даалгаж хийлгэснээр тэдний сөрөг мэдрэмжийг арилгана.

Архи, тамхи хэрэглэх, сөрөг зан үйл гаргах

Гамшиг, хямралт явдал тохиолдоогүй байсан ч хүүхэд наснаас насанд хүрсэн хүн болох шилжилтийн үе энэ насныхны гол онцлог. Энэ нь амар хялбар үйл явц биш бөгөөд энгийн цагт ч энэ насны хүүхдүүд сөрөг зан үйл, хандлага гаргах нь түгээмэл. Гамшиг тохиолдсон үед энэхүү өөрчлөлт нь хүүхдэд улам хүндээр тусаж болзошгүй. Ийм тохиолдолд хүүхдийг зэмлэж загнах нь тусгүй.

Энэ тохиолдолд дараах байдлаар хүүхдэд туслаарай:

- Уурлаж бухимдах зэргээр мэдэрч буй зүйлээ хүчтэй илэрхийлэх нь аюултай гэдгийг хүүхдэд ойлгуулна. “Иймэрхүү гамшигт үйл явдал тохиолдсоны дараа ихэнх өсвөр насны хүүхэд, бүр томчууд ч гэсэн уурлаж бухимдан, өөрийгөө захирч чадахаа больдог. Архи уух, тамхи татах нь тустай гэж тэд боддог. Хэдийгээр уурлаж бухимдах, биеэ захирч чадахгүй байх нь хэвийн зүйл боловч архи, тамхи хэрэглэх нь буруу. Тэдгээрийг хэрэглэснээр асуудал шийдэгдэхгүй шүү дээ.” гэх байдлаар учрыг тайлбарлана.
- Хаашаа явж байгаа, юу хийж байгааг нь сайтар ажиглана. “Ийм нөхцөлд чиний хаана байгааг, чамтай яаж холбогдож болох талаар би мэдмээр байна.” гэж тайлбарлана. Гэхдээ нөхцөл байдал хэвийн болсны дараа дахин ингэхгүй гэдгээ хэлнэ.
- Архи, тамхи авах боломжийг хязгаарлана.

1. Гамшгаас хамгаалах тухай Монгол улсын хууль

(УИХ, 2003)

Гамшиг, түүний төрлүүдийн тодорхойлолт, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим, бэлэн байдлын ялгаатай зэргүүд, гамшгаас хамгаалахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх үүрэг зэргийг хуульд тусгасан. Энэхүү хуулиас төрийн байгууллага болохын хувьд сургууль гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ямар ямар үүрэг хүлээх талаар дэлгэрэнгүй мэдэх боломжтой болно. Түүнээс гадна энэхүү хууль нь сургуулиас гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр явуулах бүхий л үйл ажиллагааны суурь болох юм.

Хуулийг "www.legalinfo.mn" цахим хуудаснаас татаж аваарай.

2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүүхэд хамгааллын талаарх баримтлах чиглэл

(Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2014 оны 245 дугаар тушаал)

Энэхүү баримт бичиг Онцгой байдлын асуудал эрхэлсэн ялгаатай түвшний байгууллагуудаас гадна тэдгээртэй хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, бусад иргэдэд хамаардаг тул үүнийг зайлшгүй судлах шаардлагатай. Баримт бичигт зааснаар багш, ажилтан та бүхэн Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага, түүний орон нутгийн салбараас дараах чиглэлээр дэмжлэг авах, хамтран ажиллах боломжтой:

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах
- Хүүхдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн онцлог, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан гамшгийн бэлэн байдлыг хангах, сургалт, сурталчилгааг зохион байгуулах
- Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих
- Гамшгийн үед хүүхдийг хамгаалах чадавхийг сайжруулах
- Хүүхдийн эрхэм дээд, язгуур эрхийг хамгаалах мэдрэмжтэй, хариуцлагатай гамшгаас хамгаалах түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудаснаас татаж аваарай.

3. Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-ын цахим хуудас:

www.nema.gov.mn

ОБЕГ-ын цахим хуудаснаас гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой хууль, дүрэм, журам болон цаг үеийн бусад мэдээллүүдийг авах боломжтой. Түүнээс гадна газар хөдлөлт, гал түймэр, үер ус, зуд, цасан болон шороон шуурга гэх мэт гамшгаас хэрхэн хамгаалах, гамшгийн үед ямар арга хэмжээ авах, хүмүүсийн, ялангуяа хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаарх мэдээллүүдийг авч болно. Сурагч, багш, ажилтныг гамшгаас хамгаалах чиглэлээр чадваржуулахад эдгээр мэдээлэл тун хэрэгтэй.

4. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлал (ОБЕГ, 2013)

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нийтлэг бүтцийг 1) Танилцуулга, 2) Гамшгаас хамгаалах арга хэмжээ, 3) Гамшгийн үеийн үүрэг, хариуцлагын хуваарилалт, харилцан ажиллагаа, 4) Хавсралт гэсэн дөрвөн хэсэгт авч үзсэн бөгөөд хэсэг тус бүрт юу юу багтаах талаар тусгасан аргагүйн зөвлөмж. Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахаас өмнө уг зөвлөмжийг сайтар судлах хэрэгтэй.

Зөвлөмжийг орон нутаг дахь Онцгой байдал хариуцсан байгууллагаас аваарай.

5. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргагүйн зөвлөмж (ОБЕГ, 2009)

Гамшгийн үнэлгээ хийх эрхгүйн орчин, үнэлгээ хийх дараалал, гамшгийн эмзэг байдлын үнэлгээ, түүнийг хийх дараалал, гамшигтай тэмцэх чадавхийн үнэлгээ, түүнийг хийх дараалал, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулах талаар уг зөвлөмжид тусгажээ. Энэхүү зөвлөмжтэй танилцсанаар гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх мэдлэг, чадвартай болно.

Зөвлөмжийг орон нутаг дахь Онцгой байдал хариуцсан байгууллагаас аваарай.

6. Гамшгийн эрсдэлийг бууруулахад зориулсан видео хичээл (Хүүхдийг Ивээх Сан, 2015)

Ой хээрийн түймэр, газар хөдлөлт, үер ус, хүн малын гоц халдварт өвчин, хүчтэй цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр нь 4-5 минут үргэлжлэх сургалтын видео. Уг видеог гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ажилладаг ерөнхий боловсролын сургуулийн үе тэнгийн сургагч хүүхдүүдэд зориулан бүтээсэн.

Материалыг ОБЕГ-ын цахим хуудаснаас үзэж болохоос гадна орон нутаг дахь Онцгой байдал хариуцсан байгууллагаасаа аваарай.

7. Өсвөрийн аврагч: Өсвөрийн аврагч бүлгийн чиглүүлэгч багшийн гарын авлага

(Эмхэтгэсэн Д.Сэржмядаг, Ц.Хонгорзул, 2015)

Энэхүү гарын авлага нь гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн бүлгийг хэрхэн бүрдүүлэх, чиглүүлэх талаар аргачилсан зөвлөмж бүхий 30 хуудас материал. Энэ нь гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бүлэг сурагчдыг бэлтгэх замаар сургуулийн нийт хүүхдүүдийг чадваржуулахад тун их ач холбогдолтой. Гарын авлага нь дараах агуулгаас бүрдэнэ:

- Хүүхдийн бүлгийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулах
- Өсвөрийн аврагч бүлгийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө
- Өсвөрийн аврагч бүлэгт гамшгаас хамгаалах боловсрол олгох үйл ажиллагаа (анхан түвшин)
- Өсвөрийн аврагч бүлэгт гамшгаас хамгаалах боловсрол олгох үйл ажиллагаа (ахисан түвшин)

Гарын авлагыг ОБЕГ-ын цахим хуудаснаас татаж аваарай.

8. Өсвөрийн аврагч: Өсвөрийн аврагч бүлгийн сурагчийн гарын авлага

(Эмхэтгэсэн Д.Сэржмядаг, Ц.Хонгорзул, 2015)

Энэхүү гарын авлага нь гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн бүлгийн үүрэг, оролцоо, энэхүү бүлгийн гишүүдийн үүрэг, үйл ажиллагааг харуулсан 98 хуудас бүхий аргачилсан зөвлөмж юм. Сургуулийн оролцооны бүлгийн хүүхдүүд уг гарын авлагыг нийгмийн ажилтан, багшийн туслалцаатайгаар эсвэл бие даан судлах замаар гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулах, гамшгаас хамгаалах мэдлэг, чадвартай болох, түүнийгээ бусдад түгээх чадвартай болно.

Гарын авлага нь дараах агуулгаас бүрдэнэ:

- Өсвөрийн аврагч бүлгийн тухай (бүлэг хэрхэн байгуулах, үйл ажиллагаагаа хэрхэн зохион байгуулах, бүлэг хөгжүүлэх)
- Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаа (анхан түвшин)
- Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагаа (ахисан түвшин)

Гарын авлагыг ОБЕГ-ын цахим хуудаснаас татаж аваарай.

9. Аврагч мазаалайн гарын авлага

(ОБЕГ, Дэлхийн зөн ОУБ)

Үер, газар хөдлөлт, хүчтэй цасан болон шороон шуурга, зуд, ой хээрийн түймэр, гал түймэр, аянга цахилгаан, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, ахуйн ослын үед баримтлах дүрэм, гамшгийн төрөл тус бүрт нэн яаралтай авах 10 алхмыг зураг, текстийн хослолоор харуулсан хүүхдэд зориулсан 18 хуудастай гарын авлага. Сургуулийн сурагчдад гамшгийн эрсдэлээс өөрийгөө хамгаалах, бусдад туслах мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалт, хэлэлцүүлэг хийхдээ энэхүү гарын авлагыг хэрэглэнэ.

Гарын авлагыг ОБЕГ-ын цахим хуудаснаас татаж аваарай.

Санамж: ОБЕГ-ын цахим хуудас руу ороод “Хууль, эрх зүй” гэсэн цонх дарахад хэд хэдэн сонголт гарч ирэх бөгөөд хамгийн доод талд буй “Хүүхэд хамгаалал” хэсгийг сонгоход “Өсвөрийн аврагч: Өсвөрийн аврагч бүлгийн чиглүүлэгч багшийн гарын авлага”, “Өсвөрийн аврагч: Өсвөрийн аврагч бүлгийн сурагчийн гарын авлага”, “Аврагч мазаалайн гарын авлага” гэсэн гурван авлага татаж авахаар харагдана.

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Аризона төв, 4-р давхар


Шуудангийн хаяг: Төв шуудан, ШХ-1023 Улаанбаатар 13, Монгол улс

Утас: +976-11-329365; 329371

Факс: +976-11-329361

Э-шуудан: secretary@savethechildren.mn

Вэб хуудас: www.savethechildren.mn

 Save the Children in Mongolia

 Save the Children MN